

ХЯТАД-МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТҮҮХЭН ХАНДЛАГА

Ш. Эгшиг⁸⁷

Товч утга: *Төр улсаа байгуулсан Хүннү нар хөрш Хань улстай орчуулагч хэлмэрчээр дамжуулан харьцаж байснаас эхлэлтэй хятад хэлнээс орчуулах үйл явц өнөөг хүртэл түүхэн онцлогтой хөгжжээ. Хятан улс, Их Монгол улс ба Манжийн үеийн монгол дуун хөрвүүлэгч нар хятадаас орчуулах орчуулгын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан нь дан гагц уран зохиолын төдийгүй бусад шинжлэлийн ном зохиолын орчуулгад ч хамааралтай юм. Хятадаас орчуулагч дуун хөрвүүлэгч нар чухам хэн байсан, тэдний орчуулга бусад хэлнээс орчуулж байсан уламжлалаас ямар онцлогтой байсан, шинэ болон орчин үеийн орчуулгын зохиол бүтээлийн байдлыг тодруулж, тухай тухайн үеийн орчуулгын хандлагыг тогтоохыг зорьж бичив.*

Түлхүүр үг: *орчуулгазүй, орчуулгын түүх, “дөрвөн бичиг, таван ном”, хятадын сонгодог зохиол, орчуулагч, дуун хөрвүүлэгч, “Ачлалт ном”, үлгэрч, бэнсний үлгэр*

Орчуулгын судалгааны бүтээлүүдийг ерөнхийд нь авч үзвэл, төвд болон орос хэлнээс орчуулсан ном зохиолтой жишихэд, хятадаас орчуулсан бүтээлтэй холбогдох судалгаа харьцангуй бага бөгөөд тогтолцоотой бус, хэсэг бусад байдалтай байгааг тэмдэглэх хэрэгтэй буй заа. Тэдгээр судалгаанд гол төлөв уран зохиолын орчуулгын талаархи судалгаа зонхилж байна.

Хятад хэлнээс монголчилсон зохиол бүтээлд одоо баттай мэдэгдэж буй хамгийн эртний бичгийн баримт гэвэл Сяньбийн үед хамаарч байна. “Сүй шү” хэмээх түүхийн номзүйн хэсэг (32-р бөлөг)-т Сяньби нарын үед гарсан сяньби хэлнээ холбогдох 12 номын жагсаалт буй⁸⁸ бөгөөд үүнд улсын (үндэсний) хэлний сурах бичиг, толь бичиг болон намтар зохиол, дуу шүлгийн зүйл олон байгаа нь лавтайяа тэр үед хэлний шинжлэл багагүй хөгжиж ирсний нотолгоо юм.

Сяньби нарын түүхийг гүнзгий судалсан доктор Г.Сүхбаатар энэ үед “... Ачлалт ном-ыг орчуулан ерөнхийдөө унших бичиг болгон хэрэглэж байжээ. Ачлалт ном (“Тахимдуу бичиг” ч гэж орчуулдаг)-ын эл орчуулга бол монгол хэлний анхны орчуулга гэж үзэж болох байх...” гэж тэмдэглэжээ⁸⁹. Энэ мэдээг

⁸⁷ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

⁸⁸ Louis Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, edited by L. Ligeti, Budapest, 1970, p. 279 (265-308).

⁸⁹ Г. Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971, 119-р тал.

францын монголч Франсуаз Обен баталдаг⁹⁰. Харамсалтай нь уг орчуулга бидний үед хүрэлцэн ирсэнгүй.

Ч.Нарантуяа нарын монгол бичгээс кирилл үсэгт буулгасан “Кунз” хэмээх бэсрэг номын оршил тайлбарт “471-499 онд Кэси-линг “Ачлалт ном”-ыг тоба хэл дээр орчуулжээ. Манай тооллын 480 онд Монгол Сяньби аймгийн мэргэн гүүш нар “Ачлалт ном”-ыг нангиадаас монгол хэлэнд орчуулан ард олонд түгээн тархааж байжээ.” хэмээжээ. Энэхүү мэдээг Өвөр Монгол дахь эх сурвалжаас авч бичсэн бололтой бөгөөд хэрэвзээ баримтаар нотлогдвол мөнөөхөн судалгаанд их нэмэртэй болох юм.

Хятадаас орчуулсан орчуулгад холбогдох илүү бодитой баримт гэвэл, Хятаны үед холбогддог. Хятаны түүхийг бичсэн Б.Багана, Х.Пэрлээ нар тэр цагт “...Хятаны ба Хятадын судар бичгийн хүрээлэн хоёр байжээ. Хятан хүрээлэнд хятан судар бичиг зохиох орчуулгын хэрэг эрхлүүлжээ. Хятад хүрээлэнд Хятаны харъяат Хятадын бичиг, судар зохиох ажил хийж, хятад эрдэмтэн сэхээтэн нараас улсын мөчих шалгаан авч эрдмийн зэрэг олгох ажлыг эрхлүүлжээ...” хэмээн тэмдэглэсэн хэсэг буй⁹¹.

“Ляо улсын эх адагийн хэрэг” хэмээх түүхийн мэдээгээр Хятаны томоохон язгууртан нар гэртээ номын сантай байсан бөгөөд тэнд нь хятадын дөрвөн бичиг буюу “Их суртахуй” (大学), “Ер дунд бичиг” (中庸), “Шүүмжлэл өгүүлэл бичиг” (论语), “Менз бичиг”(孟子) таван ном буюу “Зурхайт ном” (易经), “Шүлэглэлт ном” (诗经), “Засагт ном” (尚书), “Ёслолт ном” (礼记), “Шажинт ном”, “Хавар намар” (春秋) болон энэтхэг, солонгосын утга зохиолын ном байдаг байсан хийгээд заримынх нь номын тоо түм хүрч байсан хэмээжээ⁹². Тан улсын их шүлэгч Бай Жү И (白居易) болон бусад найрагчдын бүтээлээс орчуулж байсан мэдээ “Хятан гүрний ойллого” (契丹国志) түүхийн сударт тэмдэглээстэй байдгийг Я.Ганбаатар номдоо дурджээ⁹³. Үүнээс гадна, өөрснөө цаг тооны бичиг зохиож байсны хажуугаар хятадаас “Түн-ли” (通历) хэмээх Цаг улирлын нэвтэрхий бичиг болон цааз хуулийн зүйлийг орчуулж байсан баримт байна⁹⁴.

Хятан улс тухайн цагтаа бичиг соёлоо хөгжүүлж, таван нийслэл хот хийгээд муж бүртээ сургууль байгуулан, аян замын болон түүхэн тэмдэглэл зохиох, ном зохиол орчуулах, хэвлэх талаараа Ази дахинаа их л нөлөөтэй явж

⁹⁰ Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 209.

⁹¹ Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, 120-р тал (130 хуудас); Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959, 72-р тал.

⁹² *Ляо улсын эх адагийн хэрэг*, гар бичмэл, 1-р дэвтэр, 45-46, 68, 85-р тал; 2-р дэвтэр, 21-р тал; 3-р дэвтэр, 40-р тал.

⁹³ Я.Ганбаатар *Нангиадын сонгодог яруу найраг*, Таван хэлний орчуулгыг зэрэгцүүлэхүй, Улаанбаатар, 2006 он, 26-р тал.

⁹⁴ Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, 122-123-р тал (130 хуудас);

ирсэн бөгөөд 995 онд Солонгосоос хятан хэл, бичиг сурахаар хүмүүс тусгайлан ирж байсан мэдээ буй⁹⁵ нь үүний нэгэн нотолгоо болно.

Их Монгол улсын үед хятадаас ном судрын зүйл орчуулах ажил үлэмжхэн хөгжиж,⁹⁶ тэдгээр орчуулга нь ч уг эхээрээ бидний үед хүрэлцэн ирж, хятадаас монголчилсон зохиол бүтээлийн бодит судлагдахуун болдог билээ.

Өгөдэй хааны 6-р он буюу 1234 онд “Төрийн хөвгүүдийн сургууль” (国子監) Улсын хөвгүүдийн сургууль гэж хэлэх нь ч бий.) байгуулах зарлигийг хаантан буулгаснаар анхлан хааны угсааны агь ба том түшмэдийн хөвгүүдийг сургах сургууль үүсчээ. Энэ сургуульд монгол хятад бичиг үсэг эзэмшсэн тухайн үеийн хамгийн нэрт эрдэмтдээр хичээл заалгаж байжээ. Энэ сургуулийг Хятадын дараагийн түүхэн улсууд уламжлан авч, Монголчуудын тогтоосон сургуулийн тогтолцоогоор цаашид явуулсаар ирсэн бөгөөд энэхүү сургуулийн барилга одоо ч гэсэн Бээжин хотноо хадгалагдан үлдэж, тухайн цагийн түүхийг өгүүлэн оршсоор байгаа юм. 1236 онд “Бичиг зохион найруулах хүрээлэн, судар бичгийн хүрээлэнг байгуулж, судар түүх цуглуулж найруулах ажил хийлгэж эхэлсэн тухай БНХАУ-ын монголч Ж.Ринчиндорж дурджээ.⁹⁷ Энэхүү байгууллагуудад судалгаа, сургалтын ажилд шаардагдах орчуулгын ажил ихэд өрнөсөн юм. Жишээ нь, төрийн хөвгүүдэд уншуулахаар хятадын “Дөрвөн бичиг, таван ном” болон энэтхэгийн “Панчатантра”-г тусгайлан орчуулуулж байжээ. Л.Хүрэлбаатар багштаны “Монгол орчуулгын товчоон”-д ч мөн энэ талаар дурдахдаа, Хубилай хаан Жао-би гэгч эрдэмтнээр 4 номыг орчуулгажээ. 1288 оноос Төрийн хөвгүүдийн сургууль ба орон нутгийн монгол сургуульд “Их суртахуй бичиг” (大学)-ийг монголоор орчуулж, дөрвөлжин үсгээр товхисон эхээр зааж эхэлсэн байна. Үүнээс хойш он цагийн дарааллаар 1282 онд Сыма Гуан (司马光)-ы “Төрд туслах нэвтэрхий толь” (自治通鉴)-ыг 1311 оноос Тан улсын “Чжен гуань чжен яо” (贞观政要)-ыг 1317 оноос Алинтөмөр удирдан, “Их суртахуй ачлалт ном”-ыг Аллактөмөр тус тус орчуулж эхэлжээ. Тэд мөн 1326 онд “Эзэн богдын их сургаал”-ыг орчуулан хэвлэжээ. Монгол эрдэмтэн Цагаан тухайн үедээ их эрдэм төгс, ном зохиохоос гадна орчуулгын ажил хийж байв. Тэрээр Тан улсын Тайцзун хааны зохиосон “Чжен гуаний төрийн товч” (贞观政要) “Хаан эзний дүрэм”, “Шударга ном”-ыг орчуулах ажлыг хийж байв.⁹⁸

Академич Д.Цэрэнсодном: 1240 онд “*Да Сыюу Ян-ий*” (үүнийг Цэрэнсодном авгайн өөрийн бичсэнээр оруулав.) гэдэг номыг хятадаас орчуулсан гэх мэдээ буйг дурдаж, бас 1264 онд хятадын сонгомол зохиол

⁹⁵ Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959, 69-74-р тал.

⁹⁶ Чулууны Далай, *Монголын түүх* (1260-1388), гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 160-р тал;

⁹⁷ Ж.Ринчиндорж, *Дундад улс дахь Монгол судлалын тойм*, Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 1992, No.1,2 (9,10), Special issue: World Mongol Studies, Ulaanbaatar, 164-165 pp.

⁹⁸ Л.Хүрэлбаатар, *ХШ-ХIY зууны үеийн орчуулгын зохиол*, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995, 4-6-р тал.

орчуулах, түүх зохиох хороо байгуулсныг тус тус тэмдэглэснээс гадна 1307 онд “Ачлалт ном”-ыг Булутөмөр орчуулсныг тэмдэглэжээ⁹⁹.

Юань улсын үеийг судалсан манай нэрт түүхч, академич Ч.Далай: Сүн (北宋朝) улсын түүхч Сыма Гуан (司马光 1019-1086)-ы “Төрд туслах нэвтэрхий толь”- (“资治通鉴”)-ийг 1269-1271 оны хооронд, христосын тооллын өмнөх 200-аад оны үед зохиогдсон Күнзийн суртлын “Ачлалт ном” - (“孝经”)-ыг Болдтөмөр гэдэг монгол эрдэмтэн 1307 онд, “Их суртахуй бичиг” - (“大学”) -ийг 1288 оноос өмнө тус тус орчуулж монгол болон дөрвөлжин бичгээр гаргаж байсан тухай дурджээ¹⁰⁰. Энд өгүүлсэн “Ачлалт ном”-ын орчуулагчийн нэрийг академич Ч.Далай гуай Болдтөмөр гэсэн бол дээр өгүүлсэн академич Д.Цэрэнсодном гуай Булутөмөр орчуулсан гэжээ. Тэгэхээр орчуулсан цаг хугацааны хувьд нэгэн он байгаа тул энэ нь нэг хүн бололтой, гагцхүү энэхүү хүний нэрийг эш татсан эх сурвалжаас буулгахдаа өөр өөрөөр тайлж буулгасан бололтой байна. Хятадаас монголчилсон зохиол бүтээлүүдийн дотроос энэхүү зохиолын орчуулга, орчуулсан цаг хугацаа болон удаа дараа хэдэн удаа орчуулсан, түүнээс лавтайяа таван орчуулга нь бидний үед хүрэлцэн ирсэн, бидэнд хүрэлцэн ирсэн хувилбар орчуулгуудаас хамгийн эртнийх болох XIV зууны орчуулга нь дундад үеийн монгол хэлний тухайн цагийн хэлзүйн онцлог байдлыг тусгасан зэргээрээ монгол орчуулгын түүхнээ онцгой байрыг эзэлдэг. Тийм ч болохоор дээр дурдсан монгол орчуулгуудаас “Ачлалт ном”-ын “анхны” гэгдэх орчуулгыг эрдэмтэн Х.Лувсанбалдан, профессор Л.Лигети (L. Ligeti), И. де Рахивильз (I. de Rachewiltz), Ф.В.Кливец (F. W. Cleaves), Хас-Эрдэнэ зэрэг олон эрдэмтэн хэлний онцлог болон орчуулгын түүхийн талаас нь тусгайлан судалжээ¹⁰¹. Гэвч нарийвчлан хөөвөөс, доктор Г.Сүхбаатар, Ф.Обен нарын үзсэнээр “Ачлалт ном”-ыг бүр анх Сяньби нар орчуулсан гэж үзэх үндэслэл гарч байна¹⁰².

⁹⁹ Д. Цэрэнсодном, *Орчуулгын зохиолын өв уламжлалаас*, - Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972, (14 - 23-р тал) 15-р тал.

¹⁰⁰ Чулууны Далай, *Монголын түүх (1260-1388)*, гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 160, 194-р тал;

¹⁰¹ Х.Лувсанбалдан, *Ачлалт номын тухай*, *Studia Mongolica*, Tom. III, Fasc. 12, Улаанбаатар, 1961; I. de Rachewiltz, *The Preclassical Mongolian Version of the Hsiao-ching*, - *Zentralasiatische Studien*, Band 16, Wiesbaden, 1982, pp. 7-109; F. W. Cleaves, *The First Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - *Acta Orientalia Hung.*, Tom. 36, Budapest, 1982, pp. 69-88; F. W. Cleaves, *The second Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - *Documenta Barbarorum*, Festschrift für Walter Heissig zum 70. Geburtstag, Wiesbaden, 1983, pp. 272-281; L. Ligeti, *A propos de la traduction mongole préclassique de Hsiao-king*, - *Acta Orientalia Hung.*, Tom. 38, Budapest 1984, pp. 303 - 349; I. de Rachewiltz, *More about the preclassical mongolian version of the Hsiao-ching*, - *Zentralasiatische Studien*, Band 19, Wiesbaden, 1986, pp. 27- 37. Qaserdeni, *Mongᠡol kelen-ü Takimdaᠲu biᠶiq-un uge butuhu yosun*, - *Erdem sinjilegen-u sedkul*, Kukeqota, 1991, N. 2 (33), 21-27.

¹⁰² Г.Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971, 119-р тал; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - *Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries)*, Beijing, 1987, p. 209.

Юань улсын дараагаар тухайлбал: Хятадын Мин улсын үед хятадаас монголчлох үйл ажиллагаа харьцангуй саарсан байдал харагддаг бөгөөд энэ нь цаанаа улс төрийн учир холбогдолтой байж болох ч мөн нөгөө талаас тухайн үеийн Монголын төр нэлээд тогтворгүй, феодалын бутрал зэрэг түүхэн нөхцөл байдлаас болж, тухайн үеийн бичгийн зохиол бүтээл дайн тулааны хөлд устаж үгүй болоод, бидний үед уламжлагдан ирээгүй байж болох тул, тухайн цагт огт орчуулга хийж байгаагүй хэмээж болохгүй мэт. Ж.Ринчиндоржийн бичсэнээр 1369 онд эрдэмтдийг зохион байгуулж, “Юань улсын судар”-ыг бичүүлсэн ба “Монголын нууц товчоон”-ыг Юань улсын сүүл, Мин улсын эхэн үед галиглаад, монгол эрдэмтэн Хуёнгай, Маш Их нар хятадаар орчуулж, үг бүрийн махчилсан орчуулга ба бөлөг бүрийн хойно утгачилсан орчуулгыг хийсэн байна.¹⁰³ Энэ бол уг нь манай сэдэвт хамааралтай бус ч тухайн үед орчуулгын ажил мөн л ихээхэн эрчтэй явж байсныг илтгэнэ. “Юань улсын судар”-ыг Дандаа хэмээх Дэмчигдорж Ардын хувьсгалын эхний жилүүдэд (1917-1923) орчуулсан байдаг билээ.

Харин Манж Чин улсын үед хятадын зохиол бүтээлийг орчуулахад нэгэн өвөрмөц үе эхэлсэн гэж үзэх үндэс буй. Үүнд: шууд хятад эхээс нь монголчлохын хажуугаар манж орчуулгаас нь дам монголчлох ажил багагүй хөгжсөнтэй холбоотой юм. Энэ нь нэгд, манж нар хятад хэлэнд нэвтэрхий сайн байсан учир орчуулга нь харьцангуй сайн байсантай, хоёрт, монгол манж хоёр хэл нь гарал нэгтэй болохоор манжаас монголчлох нь илүү хялбар байснаар тус тус тайлбарлаж болно. Хятадын Баруун Хойдын Үндэстний Их сургуулийн Монгол хэл, соёлын сургуулийн профессор Тан Жисы *“Манжийн ноёрхлын эхэн ба дунд үед монголчуудыг хятадуудтай шууд харилцахгүй байлгах бодлого явуулж байжээ. Тухайлбал, соёлын харилцааны хувьд гэхэд монгол хүн хятад бичиг үсэг сурч болохгүй, монгол орчуулагч зөвхөн манжаас орчуулна, хятадаар орчуулж хэлмэрчлэхгүй гэх мэт хуулийн хатуу заалттай байжээ. Түүхийн сурвалжид тэмдэглэсэнээр, 1639-1644 онд Манжийн Амбагай цэцэн хааны зарлигаар ордны бичгийн түшмэлийн удирдлаган дор Түдэн, Өлзийт, Сэрэн, Соном нарын хүн “Ляо улсын түүх”, “Алтан улсын түүх”, “Юань улсын түүх”-ийг манж орчуулгаас монгол хэлнээ хөрвүүлжээ. Энэ бол Манж Чин улсын үеийн хамгийн эртний монгол хэлэнд орчуулсан орчуулга байх, хожим нь 1724 онд “Шэн юй гуан шюнь” хэмээх хаадын зарлигласан цаазыг өргөн олонд тайлбарласан бичиг, 1755 онд “Дөрвөн бичиг”, 1759 онд “Их суртахуй”, Тэнгэр тэтгэгчийн үед “Шүүмжлэл өгүүлэл бичиг”, 1785 онд “Мэнз бичиг”, 1812 онд “Ачлалт номын тайлбар”, 1832 онд “Сан зы жин” хэмээх гурван үсгийн судар гээд манж хятад монгол гурван үсгийн хадмал зохиолууд гарч байжээ. Харин Манжийн ноёрхлын сүүл үе буюу Манж улс доройтон суларсан үед хятадуудад хатуу чанд баримтлах бодлого суларснаас болон Монгол нутагт хятад иргэд*

¹⁰³ Ж.Ринчиндорж, *Дундад улс дахь Монгол судлалын тойм*, Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 1992, No.1,2 (9,10), Special issue: World Mongol Studies, Ulaanbaatar, 165-166 pp.

ихээхэн тоогоор нүүж ирж суурьших болсон зэрэгтэй давхцан заавал манж хэлээр дамжуулан орчуулдаг байсан байдал өөрчлөгдөж, монголчууд шууд хятадаас орчуулах хандлага ихэссэн юм.”¹⁰⁴ гэсэн байдаг. Тан Жисы профессорын энэ тайлбар мөн үнэний хувьтай. Үүний жишээ гэвэл, өмнө дурдсан Ч.Нарантуяа нарын шинэ үсэгт буулгасан “Кунз” гэдэг номын тайлбарт “...Манжийн хаан Түгээмэл Элбэгтийн анх он гурван сард Дин Шиуван Мен Буу хичээнгүйлэн тэмдэглэв хэмээсэн нь даруй 1850 оны гурван сар болно. Энэ орчуулгыг нангиадаас манж хэлнээ орчуулж, манжаас монгол хэлнээ буулган хэвлэжээ.”¹⁰⁵ гэж бичсэн байгаа юм. Хятадын сонгодог зохиол бүтээлийн монгол орчуулгын зохих хувь нь чухам Манж Чин улсын үед, ялангуяа уран зохиолын орчуулга энэ дундаа дийлэнх хувийг эзэлдэг. Энэ байдал Богд хаант Монгол улсын үеэс Ардын засгийн эхний үе хүртэл үргэлжилсэн нь илт харагддаг бөгөөд энэ талаар эрдэмтэд холбогдох судлагаандаа тэмдэглэсэн нь буй.

1911 онд Хятад газар Манж Чин улс унах улс төрийн үйл явдлын өмнөхөн хятад, манж хэлэнд нэвтэрсэн монголын бичгийн хүн (стилист) Балданцэрэн билигт, Цогтбадрах хичээнгүй нар Ши Най-ан (施耐庵 1296-1370)-ын “水滸”¹⁰⁶ буюу “Мөрний хариг” (“Голын хариг” ч гэдэг) хэмээх түүхэн романыг хятад хэлнээс орчуулсан гэдэг баттай баримт буй. Сүн улсын төрийг эсэргүүцсэн тариачдын их бослогын тухай буюу нэлээд ардчилсан сэдэвтэй учир 1799 оны 3-р сард Манжийн хааны зарлигаар тусгайлан хориглосон энэ зохиолыг ийнхүү орчуулсан нь ер нэг тохиолдлын хэрэг байгаагүй бөгөөд тухайн үедээ ихээхэн зориг гаргасан явдал байсан юм. Монгол улс Манж Чингийн төрөөс тусгаарлаж, Сандо амбаныг Монгол газраас хөөхөд энэхүү зохиолын орчуулга ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн гэж эрдэмтэд үздэг¹⁰⁷. Энэ ташрамд уг зохиолын өөр хэд хэдэн орчуулга байдгийг дурдмаар байна. Тухайлбал, Ванчинбалын 4 хөвгүүн Гульрансаа, Гүннацаг, Сүнвэйданзан, Инжиннаши нар бүгд монгол, хятад бичгийн хэлийг сайн эзэмшсэн, сайн найрагчид байсан агаад, Гульрансаа ахынхаа орчуулж дуусгаж амжилгүй үлдээсэн “Сүн улсын хүйтэн уулын бичиг” хэмээх дээрх “Мөрний хариг” зохиолын бас нэгэн өөр нэрт орчуулгыг нь дүү Сүнвэйданзан нь орчуулж дуусгасан тухай З.Аюурзана блог¹⁰⁸-гоо тавьсан байна.

¹⁰⁴ 唐吉思, 论清代汉文作品的蒙译, 《民族翻译》, 2011年第4期, 26-32页

¹⁰⁵ <http://nar-sar.blogspot.com/2009/05/blog-post.html>

¹⁰⁶ B.Csongor, *On the Prehistory of the Shui-Hu-chuan*, - Acta Orientalia Hung., Т. XXV, Budapest, 1972, pp.27-82; B. Csongor, *On the Popularity of the Shui-Hu-chuan (An Interpretation)*, - Acta Orientalia Hung., Т. XXVIII, Budapest, 1974, pp. 307-318; B. Csongor, *A Comparative Analysis of Shui-Hu-chuan and Hsi-Yu-chi : Rounds of the Classic Chinese Novels*, - Acta Orientalia Hung., Т. XXIX, Budapest, 1975, pp. 1-6.

¹⁰⁷ Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 373.

¹⁰⁸ Г.Аюурзана, *Ванчинбалын хөвгүүд*, <http://ayurzana.mn/>

Богд хаант Монгол улсын үеэс, Ардын засгийн эхний хэдэн жилийн хооронд хятадын олон сонгодог зохиол бүтээлийг монголчлох ажил хамгийн эрчимтэй үедээ хүрсэн байдал харагддаг нь түрүү үеийн уламжлалын эрч саараагүйтэй холбоотой буй заа. Чухам энэ үед хятадын сонгодог зохиол бүтээлийг шууд болон манжаас дам орчуулах явдал томоохон төв газраас хальж, хөдөө нутагт байгуулагдсан иргэний сургуулийг дагаж хөгжсөн байна. Үүний нэг нь Сайн ноён хан аймгийн Чин сүзэгт номун хан хутагт Цэдэнбалжирын санаачилгаар түүний шавьд 1914 онд байгуулагдсан, харчин нутгаас ирсэн Лию шансан хэмээх Мөнхтогтох багштай бага сургууль ажээ. Энэ талаар холбогдох сонин мэдээ бүхий нэгэн эшлэл татъя:

“...1915 онд Цэдэнбалжир өөрийн шадар бараа бологч Түмэнбаяр гэдэг хүнийг Хүрээнд явуулж Сэцэн хан аймагийн хурц ван Түдэнгийн номын сангаас монгол, манж, хятад түүх, уран зохиолын олон ном зохиолыг түр хугацаагаар авч хэрэглээд буцааж өгөхөөр өртөө улаагаар аваачиж байсан юм. Тэр аваачсан ном зохиолын монголыг нь харьяат түшмэд, бичээч нарт хугацаатай өгч албадан хуулуулж хувилж Богдын ба Сайн ноён ханы номын санд хүргүүлдэг байсан. Хятад утга зохиолын дотор дөрвөн гайхамшигт гэж нэрлэдэг зохиолын нэг “*Жин Пинмэй*” хэмээх зохиолыг манжаас орчуулсан бөгөөд ихэнхийг нь Мөнхтогтох багш өөрөө орчуулж, заримыг нь манж бичиг заалган сурч байсан, чадахуйц хэдэн сурагчаар орчуулгаж дараа нь өөрөө хянан засварлаж орчуулж дуусгасан болно. “*Хэ Ванюан*” хэмээх зохиолыг хятад хэлнээс өөрөө орчуулж гүйцэтгэсэн юм.

Тэр үед Богдын номын санд өгч байсан “*Жин Пин мэй*”, “*Хэ ванюан*” хэмээх зэрэг ном зохиол нь одоо Улсын Төв номын санд хадгалагдаж байна...”¹⁰⁹

Бидний мэдэхээр христосын тооллоос өмнөх нэгдүгээр зууны үеийн Хүннү, Хань улсын харилцааны талаархи үнэн баримтад үндэслэсэн “*Хэ Ванюаны бичиг*” хэмээх хоёр янзын орчуулга бүхий зохиолоос хэл найруулгын хувьд илүү сайн гэж үзсэн хавсралт зураг бүхий нэг эхийг Б. Содном 1969 онд *Дурсгалт бичигийн чуулган* цувралаар гэрэл зураг татаж хэвлэсэн нь дээрхи эшлэлд дурдсан буюу Чин сүзэгт номун хан хутагтын шавьд орчуулсан эх юм¹¹⁰.

“Монгол хятад хадмал Дөрвөн бичиг”-ийг 1926 онд Дундад Иргэн Улсын Монгол бичгийн ном хэвлэлийн товчооноос хэвлэж байжээ. Энэхүү орчуулгыг олон орчуулгатай нь тулган судалсны үндсэн дээр Харчин Тэмэгтү-ийн орчуулга хэмээн судлаачид үзсэн байдаг. Энэ ном дахин 1970 онд хэвлэгдэж

¹⁰⁹ Я. Цэвэл, *Чин сүзэгт номун хан хутагтын шавь*, - Түүхийн судлал, 25-р боть, 13-р дэвтэр, Улаанбаатар, 1990, (123-152), 149-р тал.

¹¹⁰ *Хэ ван юаны бичиг*, - Corpus Scriptorum Mongolorum, Tomus XVI, Fasc. 1, боловсруулсан Б. Содном, Redigit prof. B. Rincen, Улаанбаатар, 1969, III + 176 тал

байсан байдаг¹¹¹ нь хятад хүмүүс монгол хэл сурахад дөхөмтэй хэмээн үзсэнийх буй заа.

Богд хаант Монгол Улсын үе болон Ардын засгийн эхний жилүүдэд хятад, манж боловсрол бүхий олон хүн байсан бөгөөд тэд нар хятадын сонгодог зохиол бүтээлээс монголчлох ажил үргэлжилсээр байсан ажээ. Тэгээд ч монголын бичиг номтой хүмүүс эртний нангиадын “Шүлэглэлт ном” (诗经), Луо Гуанжуны (罗贯中) “Гурван улсын үлгэр” (三国演义), У Чен-эн (吴承恩)-ийн “Баруун этгээд зорчсон тэмдэглэл” (西游记), Цао Сюэ-чин (曹雪芹)-ий “Улаан асарын зүүд” (红楼梦), “Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан судар хэмээх бичиг”, Пү Сүнлин (蒲松龄 1640-1715)-ий Ляожайжи бичиг (聊斋志异), “Жин Пэн Мей бичиг” (金瓶梅) хэмээх цоморлиг, Ляо-Жа-гийн “Ши мэргэний шийтгэсэн хэрэг” зэрэг роман, туужийг уншсаар байсан юм. Эдгээрийн орчуулагч нар бол ХҮП-ХХ зууны үеийн нэрт гүүш нар болох Балданцэрэн, Өлзийт, Цогбадрах, В.Гульранса, Харчины Тэмэгтү, Мөнхтогтох нар байлаа. Энэ ташрамд дурдахад, хятадаас монголчилсон зохиол бүтээлийн нэлээд нь ганц бус хэд хэдэн орчуулгатай байсныг дээр дурдсан билээ. Мөн Р.Гүрбазар¹¹² судлаачийн ажигласнаар, энэ үеийн хятад уран зохиолын орчуулга нь 3 онцлогтой хэмээн дүгнэсэн байдаг. Үүнд: нэгдүгээрт, үгчлэх арга барил зонхилсон, хятад үгийг монгол бичгээр галиглан буулгасан, хоёрдугаарт, зохиолын үйл явдлыг хураангуйлсан, зохиомжилсон хувилбарууд бүхий, гуравдугаарт, эх зохиолыг монголжуулан найруулсан орчуулгууд байдаг байна. Тэрхүү монголжуулсан зохиол нь монголчуудын нүүдлийн аж ахуй эрхэлдэгтэй шууд холбоотой бөгөөд, монгол ардын аман зохиолын хөгжилтэй холбон тайлбарласан мөхөс судлаачийн тусгайлан бичсэн өгүүллээс үзэж болно.¹¹³

Хятадын зохиол бүтээлүүдийн орчуулга хийгээд орчуулагч, тархац зэргээс нь үзвэл лавтайяа өвөрлөгч нутаг, дорнод монгол, төв халх нь хятадын сонгодог зохиол бүтээлийг орчуулах гол төвүүд болж байсан нь харагддаг. Академич Ринчений судалгаа болон түүнийг баталсан шинэ олдвор зэргээс үзэхэд, хятадаас орчуулдаг төвүүдийн дээрхи жагсаалт дээр Баруун монгол зохих ёсоор нэмэгдэнэ. Үүнд: Тод бичгээр “Тансан лам баруун этгээд зорчсон тэмдэглэл” байсныг үзсэн тухайгаа академич Ринчен нэг бус удаа тусгайлан тэмдэглэсэн нь монгол орчуулгын уламжлалыг судлахад үнэтэй хэрэглэгдэхүүн болдог юм¹¹⁴. ХҮШ зууны эхээр ван Цэдэнжавын манжаас орчуулсан гэдэг “Жүн дагинын тууж”-ийн зарим хувилбар нь сударчилсан хэлбэртэй, бас маанийн зургаан

¹¹¹ 蒙汉合璧四书, 蒙藏委员会印, 中华民国六十年元月

¹¹² Р.Гүрбазар, Орчуулгын онол дадлагын үндэс, Улаанбаатар, 1996, 54-р тал

¹¹³ Ш.Эгшиг, Бэнсний үлгэрийн тухай хэдэн үг, Гадаад хэл, соёл судлал, МУИС, ГХСС, Vol 356(15), 2011, 58-63-р тал

¹¹⁴ Ринчен, Ойратские переводы с китайского, - Rocznik Orientalistyczny, Tom. XXX, I, Warszawa, 1966, стр. 59-73; Б.Ринчен, К истории перевода в Монголии, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 373-388;

үсэг нэмсэн зэргийг судлагчид ажин тэмдэглэсэн нь буй¹¹⁵. Иймд “Тансан лам...”-ыг шашны утга холбогдолтой хэмээн Баруун монголд сонгож орчуулжээ гэж үзэх үндэслэл гарч байна. Үүнчлэн, урд насандаа оо энгэсэг тавьж байсан эхийгээ шоолсны учир хойд насандаа зүс муу төрсөн гэх “Жүн дагина буюу Жүн Ү ян-ы тууж” мөн л шашны утга чанартай болохоор нь монголчууд тэр номыг тийнхүү сударчилсан хэрэг буй заа.

“Одоо байгаа сурвалжуудаас хамгийн анхны монголчилсон хятад роман бол Аранагийн 1721 онд хураангуйлж орчуулсан “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” юм. XVIII зууны эхэн үед орчуулагдан ном болсон зохиол бол “Жүн дагины тууж” (“Чи улсын хатан хаан Жун Ү яны тууж” “Жүн Ү Ян” гэж хятадаар нэрлэсэн байдаг.) эрдэмтэн Ц.Дамдинсүрэнд 1868 оны хуулмал эх нь хадгалагдаж байсан ба эдүгээ хүртэл хадгалагдсан хамгийн эртний эх хувилбар болж байгаа юм. Энэ хуулмал эхийн эхний хуудсанд уг романыг манжийн Амбагай сэцэн Дээд эрдэмтийн (1636-1643 онд хаан ор сууж байсан) үед манж хэлэнд орчуулж, Монгол ван Цэрэнжав XVIII эхэн үед монгол хэлнээ орчуулж, хожим нь 1729 юм уу 1789 онд Гандан Равжаа хутагт хуулуулжээ.”¹¹⁶ “Эрт үеийн хуулмал ном болох Жийдаан хуушааны намтар бол Мин улсын сүүл үе, Манж Чин улсын эхэн үеийн Жийдаан хуушааны адал явдлын зохиол бөгөөд, Жийдаан хуушаан бол өмнөд Сүн улсын үед аж төрж байсан бодит хүн (济公(1148—1209), жинхэнэ нэр нь 李修缘)-ий тухай өгүүлсэн ам дамжсан ба тэмдэглэгдэн үлдсэн баримтад тулгуурлан гарсан зохиол юм. “Хятадын сонгодог зохиолын монгол хэлээрх ном бүтээлийн товьёг”-т “Жийдаан хуушааны намтар” нийт 54 хуулмал эх байдаг гэдэг ба үүнээс Өвөр Монголын Их сургуулийн ойрхи ба орчин үеийн түүхийн хүрээлэнгийн хөмрөгт 1806 оны хуулмал эх хадгалагдаж байгаа нь Өвөр Монголдоо хамгийн эртний монгол гар бичмэл эх болж байна. ...1816 онд монгол хэлний орчуулагч Хасбуу “Эрт эдүгээхийн гайхамшиг сайхан үзэгдэл” зохиолыг орчуулжээ. Энэ орчуулга мөн л Хятадын Мин улсын сүүл ба Манж Чин улсын эхэн үед хамаарах эх нь “Хятадын сонгодог зохиолын монгол хэлээрх ном бүтээлийн товьёг”-т хадгалагдаж байна. ... Монгол улсад хадгалагдаж буй “Улаан асрын зүүд” зохиолын монгол орчуулга 1819 онд гарчээ. Энэ нь алдарт орчуулагч Хамба, Хасбуугийн 1847 оны орчуулснаас даруй 28 жилийн өмнө орчуулсан байдаг юм. ...1830 онд Тан улсын хааны ордны албан бус түүх ба 1833 онд уг түүхийн нэмж дэлгэрүүлсэн тайлбарт орчуулгыг орчуулагч Хасбуу гаргажээ. ... Хятадын сонгодог зохиолыг манж эхээс нь монгол хэлнээ лавтайяа хөрвүүлсэн нь бол Ц.Дамдинсүрэнгийн цуглуулгад буй Монгол ван Цэрэнжавын XVIII зуунд манжаас орчуулсан “Жүн дагины тууж”, “Жинь пин мэй” буюу Алтан бумбан дахь тэргүүлэгч цэцэг хэмээх романы 6 гар бичмэл Монгол улсад хадгалагдаж буйгаас Даваа, Ядам нарын 1910 оны орчуулга манж хэлнээс орчуулсан болох нь

¹¹⁵ Б.Л.Рифтин, В.И.Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 242-146;

¹¹⁶ 乌云娜, 清代蒙译汉小说版本述略 《民族文学研究》2009年3期

мэдэгдэж байгаа юм.”¹¹⁷ хэмээн өвөрлөгч эрдэмтэн Оюуны өгүүлэлд дурджээ. Оюунаас гадна бас бус эрдэмтний судалгаанд “Жүн дагины тууж”-ийг орчуулсан монгол ван бол Цэрэнжав гэдэг нэрээр, дээр дурдсан зөвлөлтийн эрдэмтэн Б.Л.Рифтин, В.И.Семанов нарын өгүүлэлд Цэдэнжав гэдэг нэрээр тус тус тааралдаж байна. Л.Хүрэлбаатарын “Монгол орчуулгын товчоон”-д харин “Жүн дагины түүх” хэмээх романыг XVIII зууны эхний гучаад онд Засагт хан Цэвээнжав манж хэлнээс монголд орчуулжээ”¹¹⁸ гэсэн байна. Чингэхээр он цагийн болон орчуулсан зохиолын хувьд орчуулагч нь нэг л хүн бололтой, гагцхүү Юань улсын үеийн дуун хөрвүүлэгч Булутөмөр, Болдтөмөр гэх мэтээр өөр нэрээр хятад дуудлагаас монгол хэлнээ буусантай адилаар энэхүү монгол вангийн нэрийг ч мөн гадаад хэлний эхээс буулгахдаа зарим хүн Цэдэнжав гэж, зарим нь Цэрэнжав, Цэвээнжав гэж бичсэн нь бидний үед олон хувилбар үүсэхэд хүргэжээ. Засагт хан хошой чин ван Цэвээнжав (1688-1732) бол бодит хүн бөгөөд аж төрж байсан үе “Жүн дагины түүх”-ийг орчуулсан хэмээх цаг хугацаатай ч таардаг. Улсын Төв номын санд хадгалагдаж буй энэ зохиолын хоёр хувилбар орчуулгын нэг хувилбар 27 дэвтрийн орчуулагч болохыг Л.Хүрэлбаатар багштан өөрийн бүтээлдээ тодотгон оруулсан байна.

Хятад уран зохиол XVIII зуунаас хойш Монгол газар тархах хэд хэдэн шалтгаан байв. Хятад үндэстэнтэй хаяа дэрлэн аж төрдөг монголчууд Хүннүгийн үеэс л ахуйн харилцаатай байсан ч хоёр талын улс төрийн бодлогын шалтгаанаар утга соёлын төвшинд тийм их ойртон харилцаж байсан нь түүхэндээ бараг үгүй, Монголын эзэнт гүрний үед зөвхөн дээд давхаргын язгууртнууд, тэдний удам угсааныхан хятадын гүн ухааны, уран зохиолын, хууль цаазын бүтээлийн төвшинд зохих боловсролыг тухайн үеийн тэргүүний бусад соёлын мэдлэгтэй зэрэгцүүлэн судалж эзэмшиж байжээ. Нүүдлийн соёл иргэншилтэй ард монголчууд суурин соёлын мэдлэгийг заавал хүртэх шаардлагагүй байв. Манжийн ноёрхолд байсан он жилүүдэд монгол ба хятадын аль аль нь манжийн дарлалын эсрэг ижил ашиг сонирхолтой үе байж, чухам энэ үед Манжийн шинэ засгийн бодлогын үр дүнд олон тооны дотор газрын хятад иргэн Монголын нутагт шилжин суурьшиж, тэднээр дамжин хятад соёлын нөлөө ямар нэг хэмжээнд буй болжээ. Мөн манж, хятад, төвд хэл эзэмшсэн монгол ноёд, бичгийн хүмүүсийн орчуулгын ажлын үр шимээр Манж Чин улсад тухайн үедээ хамгийн ихээр түгэн дэлгэрч байсан уран зохиолын тэргүүний бүтээлүүдийг монгол хэлнээ ихэвчлэн манж хэлээр дамжуулан, хожим XIX зууны дунд үеэс шууд хятад хэлнээс нь орчуулан хөрвүүлж байсан ерөнхий хандлага байв.

Хятад хэлээс орчуулсан зохиолуудыг монгол газар түгээн тархаахын тулд ихэвчлэн хуулж олшруулдаг байв. Төвдөөс орчуулсан шашны голдуу зохиолыг барлах хэвлэх нь элбэг байсан юм. Хошуу тамгын газрын бичээч, бичиг мэдэх

¹¹⁷ мөн тэнд

¹¹⁸ Л.Хүрэлбаатар, XIX-XX зууны үеийн орчуулгын зохиол, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995, 121-р тал.

хүмүүсийг албадан тодорхой шан харамжтайгаар орчуулгын зохиолыг хуулуулдаг байв. Хуулж олшруулсан номыг тодорхой бодлогоор заавал байх ёстой газруудад хуваарилан хүргүүлдэг уламжлал монголчуудын дунд байсан ба эдгээр газар нь харьцангуй суурин газрууд болох хүрээ, хийдийн газрууд байжээ. Хуулан бичигч нар орчуулгынх нь алдаа мэдгийг засах хэмжээний хүмүүс байвал засчихдаг, зарим хуулан бичигч алдаж хуулах, үг үсгээ буруу таньснаар өөр үг, хэллэг бичих мэтийн элдэв шалтгаанаар орчуулга өөрчлөгдөх ч явдал байсан бололтой, иймээс ч орчуулгын олон хувилбар үүссэн байх магадлалтай. Орчуулгын ном зохиол нь энгийн сургаалын зохиолыг бодвол, адал явдал, өгүүлэмж арвинтай тул, үйл явдлыг нь сэдэвлэн зохиомжилж зураг зурах, орчуулгын номонд зураг сэлт нэмж оруулсан зүйл бас мэр сэр үзэгддэг. Тэр нь номын хуудаснаас хальж, сүм хийдийн хана туурганы зураг болтлоо хөгжсөн гэхэд болно. Мөн тухайн үеийн Богд гэгээн, өндөр дээдэст зориулан зурагт номыг цөөн хувиар бас гаргадаг байсныг Үндэсний номын санд байгаа сударчилсан ном, Үндэсний түүхийн музейн сан хөмрөгт буй зарим тоглоом наадгайн дээрх зураг дүрс ба Богдын сан хөмрөгт байсан эд зүйлс зэргийн зураг чимэглэлээс бүр илүү судлан гаргах боломжтой, энэ бол бас л судлууртай нэгэн сэдэв билээ.

Орчуулсан бүтээл энгийн ардын дунд тархах үйл явц нь нэлээд онцлогтой байв. Хятадын орчуулгын ном зохиолыг хадгалаад, аваад яваад байх нь нүүдлийн аж амьдралтай монголчуудын хувьд их тохиромжтой бус байдаг байсан тул ихэвчлэн монгол аман зохиол тархан хөгждөг уламжлалаар ам дамжин яригдах хандлага их байв. Тэд номтой, бичигтэй хүнээр хятад зохиолыг уншуулж дуудуулан сонсож аваад, дараа нь тэр агуулгыг нь цааш ам дамжуулан үлгэр мэт ярьдаг байжээ. Ам дамжин ярихдаа, зарим агуулгыг нь гээх, эсвэл шинээр зохиомжилж нэмэх, хятад ахуйн юмыг нь ойлгомжгүй бол монгол ахуйн юм болгож өөрчлөн монголжуулах замаар уг аман зохиол анхны хятад эх зохиолоос танигдахгүй болтлоо өөрчлөгдөн нутагшдаг байсан байна. Чингэхээр орчуулагч нарын тухайд манж ба хятад эхээс нь шууд орчуулагч тодорхой нэр бүхий хүн байхад, мөн дам орчуулан хөрвүүлэгч нар бас байжээ. Тухайн үеийн шууд орчуулагч нар орчуулгаа хийж дуусгаад хэн гэдэг хүн, хаана, хэдийд, хэрхэн тэрхүү зохиолыг орчуулсан тухайгаа заавал бичиж үлдээдэг байсан нь эдүгээ орчуулгын судалгаа хийхэд ихээхэн нэмэртэй байна. Гэвч нүүдлийн ахуйтай монголчуудын хувьд ном хадгалах нь олон удаагийн нүүдэл суудлын үед үрэгдэж үгүй болдог, хадгалж үлдсэн, энд тэндээс олдсон ном, гар бичмэлүүдийн эх адгийн хуудас нь үрэгдэж үгүй болсноос, тухайн ном ямар нэртэй болох, хэн зохиосон, эсвэл орчуулсан тухай бичээстэй байсан хэсэг нь алга болсон байх нь элбэг. Гэвч үүнийг уншигч ардын хувьд хэн орчуулсан нь гол бус доторхи уран нарийн, хоор хоорондоо холболдсон, ээдрээтэй хийгээд сургамжтай үйл явдал нь сонин содон байдаг. Ард олны дунд хятад уран зохиолын агуулгаас ам дамжин яригдаж, аман зохиол болтлоо хөгжсөн нэг жанр бол бэнсний үлгэр билээ. Бэнсний үлгэр бол магтаал, тууль хайлдаг баруун

монголчуудын аман соёлын орон зайг зүүн монголын орон зайд нөхөж өгсөн байдаг. Бэнсний үлгэрийн агуулга өгүүлэмж ихэвчлэн хятадын сонгодог уран зохиолоос сэдэвлэсэн байдаг онцлогтой.

Хятадын уран зохиолыг орчуулж монголын ард олонд хүргэсэн байдлаас харахад, өнөөгийн бидний ойлгодог орчуулагчийн төдий бус харин олон хүн орчуулагч, дуун хөрвүүлэгч байжээ гэмээр байгаа юм. Орчуулагч хэмээн үзүүштэй хүмүүст шууд ба дам орчуулагч нар, орчуулах ажил эрхэлсэн ч, нэр нь үл дурдагдсан орчуулагчид, хуулан бичигч нар, орчуулгаар сэдэвлэн зурдаг зураач нар, сэдэвлэн зохиомжилж ая данг нь тааруулан үлгэр хайлдаг үлгэрч туульч нар цөм орно. Эдгээр хүмүүс XVIII зуунаас XX зуун хүртэл бодитойгоор орчуулж туурвих ажлыг эрхэлсээр ирсэн гэхэд болно.

1921 оны ардын хувьсгалын дараахан Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, эрдэм шинжилгээний зорилгоор монгол болон монголчуудтай шууд болон дам холбогдол бүхий олон түүх, судрыг хятад, манж хэлнээс монголчлох ажлыг бодлоготой хийж иржээ. Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайд О.Жамъян, эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээн нарын идэвх санаачилгаар Монгол Улсын номын санг байгуулах ажлыг гардан хийж, "...гадаад хэлээрх ном 2400 орчим, монгол хэлний ном судар 700, төвд үсгийн ном 250, хятад манж, япон зэрэг хэлний ном 1400 орчмыг нийт 3000 лан мөнгөөр хураан цуглуулж чаджээ."¹¹⁹ Эдүгээ манай Үндэсний номын санд гар бичмэлээр хадгалагдаж буй хятад зохиолын монгол орчуулгын гар бичмэлүүдэд уран зохиолын, хятад албан түүхийн, күнзийн суртлын сургаалын, эмзүй, анагаах ухааны, хадмал ба орчуулгын толь зэрэг олон салбарын 500 орчим бүтээл байгаагийн ихэнхийг Судар бичгийн хүрээлэнгийн анхдагч нарын хүчин зүтгэлээр олж цуглуулжээ. Хятад хэлнээс орчуулсан монгол орчуулгын зохиолууд Монгол Улсаас гадна БНХАУ, ОХУ, Герман, Дани, АНУ, Япон, Унгар, Швед улсын номын санд хадгалагдаж байдаг¹²⁰ байна.

Хятадын эртний томоохон хэмжээний уран зохиолуудыг энд авч үзсэн бөгөөд үүний хажуугаар төр ёсны түүх (тухайлбал Шань гүрний бичиг, Жоу улсын бичиг, Зүүн Хань улсын бичиг, Баруун Хань улсын бичиг, Вэй улсын бичиг, Тан улсын бичиг, Юань улсын судар зэрэг) шаштир, сургаал номлолын чанартай болон анагаах ухааны салбарын ном бүтээл нэн олноор нь монголчилсныг дахин судлах хэрэгтэйг тэмдэглэе.

Ийнхүү хятадын эртний сонгодог зохиол бүтээл, түүх шаштирыг монголчлох явдал мянга есөн зуун гучаад оноос тавиад он хүртэл улс төрийн шалтгаанаар саарч, дараа нь БНХАУ-ын шинэ цагийн уран зохиолыг орчуулах ажилтай залгах болсон байна.

¹¹⁹ С.Чулуун, Жамсраны Цэвээн ба Монголын Судар бичгийн хүрээлэн <http://cyrillic.surag.net/?p=303>

¹²⁰ 乌云娜, 清代蒙译汉小说版本述略《民族文学研究》2009年3期

1952 онд “Буурал бүсгүй” жүжгийн зохиолыг Э.Түмэнжаргал орчуулж, Ванган найруулан тавьж байв. Орчуулагч Э.Түмэнжаргал мөн “Хятад зохиолоос” хэмээх түүвэрлэсэн орчуулгаа 1956 онд гаргажээ. Ма Фын-ы “Малчин Чжао Да-шу”-г Л.Дарий 1956 онд, Ө.Гүрсэд 1957 онд Мао Дуний “Үнэгэн харанхуйд” роман, Гуо Моруо-ийн “Шанхайн өглөө” зохиолыг орчуулан 1958 онд хэвлүүлэн гаргасан байдаг. Жоу Либао-гийн “Догшин салхи, ширүүн бороо”¹²¹ романыг Б.Бат, Х.Төмөрдөш нар 1957 онд орчуулжээ. Г.Сүхбаатар 1965 онд Лао Шө-ийн “Тэмээн сянцзы” зохиолыг орчуулсан байна.

Үүний дараа 60-аад оноос хойш хятадын уран зохиолын эртний ба дундад үеийн сонгодог зохиолууд болон хятадын шинэ үеийн зохиолуудын үйл явдлыг үзүүлсэн өнгөт зураг бүхий, авч явахад авсаархан, жижиг хэмжээтэй хэвлэгдсэн ном маш ихээр гарч байсныг хижээл, ахимаг насны хүмүүс мэднэ. Тэр нь одоогийн комикс зохиолтой адил шийдэлтэй номууд байсан билээ. Жишээ нь, “Сун У Кун”, “Буурал үст бүсгүй”, “У Кун барсыг дарсан нь” г.м. Яг энэ төрлийн номын орчуулгыг хэрхэн хийж байсан, хэвлэлийн зураг дүрслэлийг хэн зурж байсан, хаа хэвлэж байсан, комикс номтой харьцуулах зэргээр судлах эзнээ хүлээж буй нэгэн сайхан сэдэв байнам гэж бодож байна.

“МУИС-ийн профессор багш, нэрт манжич Шаарийбуу багш маань нангиадын яруу найргийн шижир тунгаамал болсон “Шүлэглэлт ном” хэмээх сонгодог их цомгийг манж, хятад, япон хэлнээс тулган орчуулж дуусгажээ.”¹²² Үүнийг хийхэд арав гаруй жилийн хүч хөдөлмөрөө зориулсан тухай шавь Баярсайхан нь бичиж үлдээсэн юм.

Орчин үеийн хятад уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан нэрт төлөөлөгч дунд МУИС-ийн эрдэмтэн багш, зохиолч Монгол Улсын гавьяат багш, МОХ-ны “Дуун хөрвүүлэгч” шагналт Ц.Базаррагчаагийн орчуулга жинтэй суурь эзэлнэ. Лао Шөгийн “Хавирган саран”, “Шүлэглэлт ном”-ын орчуулга, Хо Ши Миний “Шоронгийн тэмдэглэл”, Хятадын орчин үеийн яруу найрагчдын 51 шүлгийн орчуулга бүхий “Тэрлийн дуун” болон Тайваний монгол гаралтай зохиолч Ши Мөрөнгийн “Цагаан хэрмийн чанад нутгийн дуу” орчуулгын түүвэр зэрэг багтана. Мөн Хятадын алдарт найрагч Чюй Юаний “Самуурлаас салан одохуй”¹²³ хэмээх найраглалыг 2013 онд орчуулжээ.

М.Чимэдцэеэ багштан хятадын уран зохиолын орчуулгын судалгааг дорвитой хийж, Хятадын сонгодог уран зохиолын дээж цувралаар Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл”, “Их суртахуй”, “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолуудыг

¹²¹ БНМАУ-ын 1945-1958 онуудад монгол хэл дээр хэвлэгдсэн номын товч бүртгэл, 759. УХХЭХ, Улаанбаатар, 1960, 66-р тал

¹²² М.Баярсайхан, “Зуу дахь хавраа угтаж буй МУИС-ийн хүндэт профессор”, “Өдрийн сонин”-ы 2009.01.16. №011-д

http://smlc.num.edu.mn/index.php?option=com_content&view=article&id=355

¹²³ Ц.Базаррагчаа, “Самуурлаас алан одохуй”, “Монголын Хятад судлал” МУИС, Туршилтын дугаар, Улаанбаатар, 2014, 204-220-р тал

орчуулан, хэвлүүлэн гаргасан билээ. Мөн Хятадын орчин үеийн эмэгтэй зохиолчдын шилдэг өгүүллэгийн дээжис “Халуун тогоо” орчуулгын номоо 2014 онд хэвлүүлэв.

Мөн доктор, профессор Д.Болдбаатар бол хятадаас монгол хэлэнд орчуулагчдын сүүлийн үеийн нэртэй зүтгэлтэн гэж үзэхээс аргагүй юм. Тэрээр орчин үеийн тользүйн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж буй төдийгүй “Журамт бүсгүй Лү Би Лянь”, “Мөрөн голын шулам хүүхэн”, “Чонон сүлд”, “Гурван улсын үлгэр” “Төвд банхар”, Муухай хятад хүн” зэрэг үргэлжилсэн үгийн зохиол, Монголын Радиогийн нэвтрүүлэгт орсон “Дү Фүгийн шүлгүүд” “Сун улсын яруу найрагч Жоу Бан Яны бүтээлүүд” зэрэг орчуулгын найрууллууд болон орчин үеийн орчуулгын шинэ жанр болох кино дэлгэцийн бүтээлийн орчуулгаар эдүгээ Монгол улсад “толгой цохиж”, 50 гаруй олон ангит цуврал бүтээл болон уран сайхны кино орчуулжээ.

Я.Ганбаатар багштаны түүх, уран зохиол, яруу нийтлэлийн бүтээлийн цуваа тасардаггүй бөгөөд түүний орчуулгын бүтээлүүдэд Хятадын богино өгүүллэг ба сонгодог яруу найргийн орчуулга давамгайлдаг. Зүгээр нэг орчуулаад өнгөрөхөөс илүүтэй, тухайн орчуулгыг хятад шүлэг, яруу найргийн онцлог болох “гурван мэдрэхүйн хүртээмж”-ит чанарыг (унших, сонсох, харах гурван мэдрэмжийг хятад хэлний онцлог болох үсэг бичигтэй нь холбон тайлбарладаг.) нь монгол хэлнээ буулгах хэрийн хүн барьж аваад хийчихгүй тэрхүү яруу найргийн орчуулгаа бусад хэлний орчуулгатай нь хадаж хэвлүүлсэн “Нангиадын сонгодог яруу найраг” хэмээх бүтээл нь судлаач, суралцагсад тун их тустай бүтээл болсон юм.

О.Адъяа агсан 2002 онд Жу Яоминий “Чингис хааны түүх шастир” номыг орчуулан хэвлүүлжээ. Тэрээр аль залуу ахуйгаас хятадын сонгодог яруу найраг ба Гуо Муруо-ийн зохиолоос орчуулж байсан ба хамгийн сүүлд Өвөр Монголын кино найруулагч Буяндалайн “Чингис хаан”¹²⁴ олон ангит киноны зохиолыг монголчилсон юм.

Орчин үеийн орчуулгын бүтээлд хятад зохиолыг хятад хэлээс бус, өөр хэлний орчуулгаас нь монгол хэл рүү орчуулдаг үзэгдэл нэлээд бий. 1960 онд манай нэрт дорны их яруу найрагч Б.Явуухулан ба нэрт орчуулагч Ч.Чимэд нарын “Ли Бо” хэмээх шүлгийн түүврийг орос хэлнээс орчуулж гаргаж байв. Дэлхийн сонгодог утга зохиолын чуулганд “Алтан бумбан дахь лишийн цэцэг” романыг орчуулагч Б.Дашцэрэн мөн орос хэлнээс 2009 оны орчуулан оруулжээ. Дашрамд дурдахад, энэ зохиолын нэр уг нь “Алтан бумбан дахь тэргүүлэгч цэцэг” гэж орчуулан буулгахаар байтал, чухам яагаад “лишийн цэцэг” болчихсон юм бол, магадгүй зохиол бичигдсэн эх хэлээс нь орчуулалгүй, хэл дамжуулан орчуулаад ингэж нэр нь өөрчлөгдсөн болов уу хэмээн сэтгэв.

¹²⁴ *Оцолын Адъяа багш*, Монгол Улсад Хятад судлалын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний түүхийн товчоон, Улаанбаатар, 2007 он. 110-р тал

Сүүлийн жилүүдэд хятад хэлнээс Г.Мэнд-Ооёо, Ц.Сүрэнжав, М.Шагдарсүрэн, М.Цагаанхүү, М.Равдандаш, Д.Одонхорлоо нарын орчуулгын бүтээлүүд гарлаа. Орчуулагч Нацагдоржийн Энхбаяр “Орчин үеийн хятад яруу найраг” орчуулгын түүврээрээ Монголын Зохиолчдын Эвлэлээс олгодог 2015 оны шилдэг бүтээл “Алтан өд” шагналыг утга зохиолын орчуулгын төрөлд хүртжээ. Мөн Монголын Орчуулагчдын Эвлэлийн нэрэмжит дэлхийн сонгодог, шилдэг уран зохиолын орчуулгын уралдаанд Б.Гэрэлт-Ирээдүй, н.Гэрэлмаа, Э.Оюундарь нарын орчуулагчид хятад хэлнээс орчуулсан бүтээлээрээ байр эзлэн бүтээл нь хэвлэгдсэн билээ. Бас хятад түүхийн сурвалж бичгийг орчуулан, тайлбар хийх ажил манай эрдэмтдийн дунд сэргэж байгаа юм. Тухайлбал, түүхч эрдэмтэн Ц.Цэрэндорж, Д.Ундрах нар “Умар газар одсон хувийн тэмдэглэл, Умрыг төвшитгөсөн тэмдэглэл”¹²⁵ хэмээх Монголын эзэнт гүрний дараахь үед хамаарах хоёр сурвалжийн орчуулгыг хийж, тайлбартайгаар хэвлэн гаргав.

Орчин үед хятад хэлнээс орчуулахдаа монгол орчуулагч нарын хувьд хятадын сонгодог зохиол бүтээлийг түлхүү орчуулах, олон улсын хэмжээнд нэрд гарсан зохиол ба зохиолчийн бүтээлийг олж орчуулах гэж мэрийдэг хандлага байгаа юм. БНХАУ-аас зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэхээ өнөөгийн Хятадын удирдагчид ил зарласан бөгөөд энэ бодлогын хүрээнд гадаадын орчуулагч нарыг хятадын орчин үеийн бодлого ба хятад соёл ахуй, уламжлалыг үзүүлсэн зохиол, хятадын залуу үеийн зохиолчдын бүтээлийг орчуулах явдлыг хөхүүлэн дэмжих бодлого явуулж байгаа юм. Энэ хүрээнд сүүлийн жилүүдэд БНХАУ-ын жил бүрийн Лу Шюнийн нэрэмжит шагналт зохиолчдын бүтээл, бусад улсын хэмжээний утга зохиолын уралдааны шагналт зохиолыг өвөрлөгч орчуулагч нар монгол хэлнээ орчуулан гаргаж байна. Өвөрлөгчид хятад хэлнээс монгол руу орчуулах ажлыг дорвитой хийж байдаг нь таатай хэрэг юм. Тэд бээр “Дай Юань улсын түүх”¹²⁶, “Дай Ляо улсын түүх”, “Алтан улсын түүх”¹²⁷, “Монгол Татарын бүрэн тэмдэглэл”¹²⁸, “Хар татарын хэрэг явдлын товч”¹²⁹ гэсэн түүхийн судруудыг монголчлон хэвлүүлсэн юм.

Энэхүү өгүүлэлд нэр бүхий нэг сэдэвт монограф, бүхэл зохиолын орчуулгыг оруулсан бөгөөд үүнээс гадна Намын Төв хороо, Яам тусгай газруудын захиалгат орчуулга их байдаг байсан хийгээд, “Үнэн” сонин, “Ажилчны зам” сонин, “Утга зохиол, урлаг”, “Пионерийн үнэн”, “Ил товчоо” сонин хийгээд бусад төвийн хэвлэл, “Оч” сэтгүүл, Монголын Радио, Мон-Ца-Мэ агентлаг, одоогийн чөлөөт хэвлэл, зурагтын нэвтрүүлгээр орсон хятадаас орчуулсан бүтээлүүдийг энд нэгтгэн оруулж чадаагүйдээ хүлцэл өчиж, энэхүү талбар мөн л судлах эзнээ хүлээж буй гэдгийг онцолъё.

¹²⁵ Умар газар одсон хувийн тэмдэглэл, Умрыг төвшитгөсөн тэмдэглэл, Улаанбаатар, Содпресс ХХК, 2016.

¹²⁶ *Дай юань улсын түүх*. Бээжин, 1987.

¹²⁷ *Алтан улсын түүх*, Бээжин, 1988.

¹²⁸ Жао Хун “*Монгол татарын бүрэн тэмдэглэл*” Хөх хот., 1985

¹²⁹ 黑鞑事略 (彭大雅撰) (蒙文)

Бичгийн орчуулагч нараас гадна Хүннүгийн үеэс үүдэлтэй хэлмэрч нарын талаар дурдалгүй өнгөрөх аргагүй юм. Хүннү гүрэн ба Их Монгол Улсын аль аль нь олон үндэсний хүмүүсийн элдэв хэлийг ойлгох сайн хэлмэрч нар хэрэгтэйг хамгийн ихээр ойлгосон улс байжээ. Хань улсын түүхэнд Хүннүгийн шаньюй хэлмэрчтэй байсан¹³⁰ тухай хэд хэдэн мэдээ занги бий. Хубилайн хажууд олон хэлний гүүш нар олон үндэстний хэл ул болж байсан тухай мэдээ занги нэлээд байдгийг Л.Чулуунбаатар багштан “Аман орчуулгад анхаарах зүйл их бий” илтгэлдээ дэлгэрэнгүй өгүүлж байсан¹³¹ билээ. Эдүгээ цагт хам цагийн хэлмэрчлэхүй, цуваа цагийн хэлмэрчлэхүйн бүхэл бүтэн шинжлэх ухаан үүсч хөгжсөн бөгөөд хятад хэлний нэртэй хэлмэрч нарын тоонд О.Адъяа, С.Голиминсэй, Л.Манлажав, Д.Баньдхүү, Дүнгэрийчил, Р.Нармандах, Я.Ганбаатар, Г.Байгалмаа, С.Энхбаяр, Т.Батцэцэг, Г.Бумцэнд нарыг дурдаж болно. Тэдний ихэнх нь төрийн орчуулгыг нэр төртэй хийж байсан билээ.

Дүгнэлт

1. Хятадаас орчуулсан уран зохиолын зүйлийг хэдэн зууд хүрнэ гэж академич Б.Ринчен үзсэн байдаг¹³². Я.Цэвэлийн боловсруулан нийтлүүлсэн “Улсын Номын сангийн Азийн ангид бүхий монгол ангийн бичмэл ба дармал ном бичигийн бүртгэл” хэмээх шинэ зарчмаар 1937 онд анх Монголд гарсан номзүй болон 1960 онд гарсан Жадамбын “Улсын нийтийн номын сангийн бичмэл зохиолын номын гарчиг”, ШУА-ын Түүхийн Хүрээлэнгийн сан хөмрөгт буй хэрэглэгдэхүүний жагсаалт зэргээс үзэхэд хятадаас орчуулсан уран зохиол, түүх шаштир, бусад холбогдол бүхий зүйл гээд нийт зохиол бүтээлийн тоо лавтай хэдэн зуу хүрэх нь тодорхой харагдана¹³³.
2. Хятадаас монголчилсон хэдэн зуун зохиол бүтээлүүдийн хувьд орчуулгын талаас нь судалсан судлагаанд гол төлөв хятадын эртний уран зохиолын зүйл хамрагдсан байх¹³⁴ ба түүх шаштир, анагаах ухаан гэх

¹³⁰ Ш.Эгшиг “译” хэмээх үсгийн гарлын асуудалд, Орчуулгазүй, МУИС, Улаанбаатар, 2013, 106-110-р тал

¹³¹ Л.Чулуунбаатар, Аман орчуулгад анхаарах зүйл бий, Орчуулах эрдэм (3), “Орчуулга болон тользүйн асуудалд” Олон улсын хурлын өгүүллийн эмхэтгэл, Улаанбаатар, 2011.05 сар, 110-121-р тал

¹³² Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 373.

¹³³ Cebel, *Ulus-un nom-un sang-un Azi-yin anggi-dur bukui mongol anggi-yin bicimel ba darumal nom bicig-ud-un buridkel*, Ulaganbagatur, 1937, (III+161); Jaddungba, *Ulus-un neyitu-yin nom-un sang-un bicimel jokiyal-un nom-un garcig*, Ulaganbagatur, 1960, (III+117).

¹³⁴ Ринчэн, *Ойратские переводы с китайского*, - Rocznik Orientalistyczny, Tom. XXX, I, Warszawa, 1966, стр. 59-73; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 371-386; Э. Түмэнжаргал, *Тансан ламын баруун этгээдэд зорцсоныг тэмдэглэсэн түүх гэдэг зохиолыг монгол хэлнээ орчуулсан нь*, - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968, 175-210-р тал; Э. Түмэнжаргал, *Сүн улсын хүйтэн уулын бичиг* - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968, 211-227-р тал; Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 234-279; Boris Riftingin, *Mongolian translations of old Chinese novels and stories - A tentative bibliographic survey*, - Literary Migrations,

- зэрэг бусад салбарын орчуулгын бүтээлүүд зохих ёсоор тогтолцоотой судлагдаж амжаагүй ажээ. Хэдий тийм боловч хятадаас монголчилсон зохиол бүтээлийн дотор хятадын эртний уран зохиол, гүн ухааны бүтээлүүд багагүй хувийг эзэлдэг учир наад зах нь тэр хүрээндээ монгол орчуулгын уламжлал, онцлогийг илэрхийлж чадна гэж үзэх үндэс буй.
3. Зөвлөлтийн эрдэмтэн Борис Рифтин, В.И.Семанов нар эртний хятадын роман, туужийн монгол орчуулгуудын ерөнхий төлөвийг хятад эх зохиолтой нь харьцуулан номзүйн байдлаар удаа дараа авч үзсэн ба эдүгээ Монгол улсын эрдэмтэд Хятадын гүн ухаан, сургаалын зохиолд зохих төвшинд орчуулгын судалгааг хийгээд байгаа билээ.¹³⁵
 4. Хятадаас монголчилсон зохиол бүтээлийн бараг ихэнх нь хэд хэдэн орчуулгатай байх бөгөөд тэр болгоны орчуулагч, орчуулсан цаг үе тодорхойгүй, цөм өөр өөр нэртэй байдаг. Нэг жишээ татахад: Ши Найанийн “*Шүй-хү жуань*” гэдэг романы монгол орчуулга гэхэд л “*Sui qi juwan*”, “*Усан балгамалын бичиг*”, “*Голын тохой*”, “*Мөрний хариг*”, “*Сэрүүн тунгалаг уулын бичиг*”, “*Сүн улсын хүйтэн уулын бичиг*” гэдэг олон нэрээр дайралддаг байна. Монголын бичгийн хүмүүн Гульранса энэ зохиолыг орчуулж байсан гэх мэдээ буйн дээр бидний мэдэхийн хэрээр Балданцэрэн, Цогбадрах нар орчуулсан гэх баттай баримт буйг дээр өгүүлсэн.
 5. Хятаны судар бичгийн хүрээлэнгээс эхлэлтэй орчуулгын ажлыг эрхлэх уламжлал, Их Монгол Улс ба удаахь үеийн Монголын шашны ба засаг захиргааны төвүүдэд төвлөрч байв. Монгол газар ихэвчлэн төв суурин газар төвлөрч орчуулан, хуулж олшруулан тараадаг байсан ба тэдгээр нь голдуу иргэний чиглэлийн зохиол тул энэ нь монголчуудын дунд аман хэлбэрээр тархаж, “Бэнсний үлгэр” хэмээх уран зохиолын нэгэн төрөл жанр болтлоо хөгжсөн нь хятадаас орчуулсан зохиолын бусад хэлнээс орчуулсан зохиолын хөгжлөөс ялгарах нэгэн онцлог болдог юм.
 6. Хятадаас орчуулсан зохиол бүтээлд зохиолын хэл, найруулгын тал нь бусад орчуулгын зохиол, тухайлбал: төвдөөс үгчлэн орчуулдаг уламжлалаас огт өөр, илүү монголжуу, зарим нь монгол хэлний яруу тансаг найруулгын жишээ болдог, зарим нь уг эхдээ баригдалгүй чөлөөтэй орчуулсан, уг хятад эхдээ үргэлжлүүлсэн зохиолыг монгол орчуулгад нь бүлэглэж хуваасан, зураг чимэглэл нэмж хавсаргасан гэх зэрэг олон онцлог буйг нэлээд эртнээс нэрт монголч Б. Я. Владимирцов,

Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 213-262; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 209-212.

¹³⁵ E. Haenisch, *Der Chinesische Roman im Mongolischen Schrifttum*, - Ural-Altische Jahrbucher, Band 30, Wiesbaden, 1958; W. Heissig, *Geschichte der mongolischen Literatur*, Band 1-2, Wiesbaden, 1972.

нангиадач В. Алексеев, академич Ринчен нарын зэрэг бас бус судлагчид удаа дараа онцлон тэмдэглэсэн нь бий¹³⁶.

7. Хятадаас монголчилсон зохиол бүтээлийн нэгэн нийтлэг онцлог бол хадмал орчуулга ихээхэн зонхилдог нь хэлүүдийг зэрэгцүүлэн судлах, шинээр хэл үзэж буй суралцагч нарт ихээхэн боломж өгдөг орчуулгазүйн уламжлалт нэгэн арга билээ.
8. Хятадаас монголчилсон орчуулгууд нь монголчуудыг хятадын сонгодог зохиол бүтээлтэй танилцуулах гүүр болоод зогссонгүй, Хятад газар уг эхээрээ үгүй болсон гэх “*Жүн дагинын тууж*” (буюу “*Жүн Үян*”), “*Цю хайтан*” болон энэ хир хятадаараа олдоогүй байгаа бас бус роман туужууд¹³⁷ монгол орчуулгаар ийнхүү үлдэн хоцорсон нь монголчуудын хувьд хүн төрөлхтний соёлын түүх, өв санд оруулсан нэгэн гавъяа гэж үзэх бүрэн үндэстэй ажээ.

Номзүй

Монгол хэлээрх ном товхимол:

1. *Орчуулах эрдэм* (цуврал), Улаанбаатар, 1972, 1989;
2. Р.Гүрбазар, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, Улаанбаатар, 1996;
3. *Орчуулгын хэл найруулгын тухай өгүүлүүд*, Улаанбаатар, 1996,
4. Л. Хүрэлбаатар, *Монгол орчуулгын товчоон*, Улаанбаатар, 1995;
5. Э.Түмэнжаргал, *Тансан ламын баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх гэдэг зохиолыг монгол хэлнээ орчуулсан нь*, - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968,
6. Э.Түмэнжаргал, *Сүн улсын хүйтэн уулын бичиг* - Монголын уран зохиолын тойм, III дэвтэр, Улаанбаатар, 1968,
7. Ринчен, *Марк твений минь махы нь идэж дээ*, Эмхэтгэн эрхэлж оршлыг бичсэн Г. Аким, Улаанбаатар, 1991, 230 хуудас;
8. Г. Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971,
9. Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, (130 хуудас);
10. Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959,

¹³⁶ В. Я. Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 3; В. А. Алексеев, *Китайская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 17; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 376. Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 272;

¹³⁷ В. Я. Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 238, 241-243, 263.

11. *Ляо улсын эх адагийн хэрэг*, гар бичмэл, 1-р дэвтэр, 2-р дэвтэр, 3-р дэвтэр,
12. Я.Ганбаатар *Нангиадын сонгодог яруу найраг*, Таван хэлний орчуулгыг зэрэгцүүлэхүй, Улаанбаатар, 2006 он,
14. Чулууны Далай, *Монголын түүх* (1260-1388), гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992,
15. Ж.Ринчиндорж, *Дундад улс дахь Монгол судлалын тойм*, Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 1992, No.1,2 (9,10), Special issue: World Mongol Studies, Ulaanbaatar,
16. Д. Цэрэнсодном, *Орчуулгын зохиолын өв уламжлалаас*, - Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972,
17. Х. Лувсанбалдан, *Ачлалт номын тухай*, Studia Mongolica, Tom. III, Fasc. 12, Улаанбаатар, 1961;
18. Г.Аюурзана, *Ванчинбалын хөвгүүд*,
19. Я. Цэвэл, *Чин сүзэгт номун хан хутагтын шавь*, - Түүхийн судлал, 25-р боть, 13-р дэвтэр, Улаанбаатар, 1990, (123-152),
20. *Хэ ван юаны бичиг*, - Corpus Scriptorum Mongolorum, Tomus XVI, Fasc. 1, боловсруулсан Б. Содном, Redigit prof. В. Rincen, Улаанбаатар, 1969, III + 176 тал
21. Р.Гүрбазар, *Орчуулгын онол дадлагын үндэс*, Улаанбаатар, 1996, 54 тал
22. Ш.Эгшиг *Бэнсний үлгэрийн тухай хэдэн үг*, Гадаад хэл, соёл судлал, МУИС, 23. ГХСС, Vol 356(15), 2011, 58-63-р тал
23. Ш.Эгшиг “*ᠶᠡᠰᠡ*” хэмээх үсгийн гарлын асуудалд, Орчуулгазүй, МУИС, Улаанбаатар, 2013, 106-110-р тал
24. *БНМАУ-ын 1945-1958 онуудад монгол хэл дээр хэвлэгдсэн номын товч бүртгэл*, 759. УХХЭХ, Улаанбаатар, 1960, 66-р тал
25. М.Баярсайхан, “*Зуу дахь хавраа угтаж буй МУИС-ийн хүндэт профессор*”, "Өдрийн сонин"- ы 2009.01.16. №011-д
26. *Оцолын Адьяа багш*, Монгол Улсад Хятад судлалын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний түүхийн товчоон, Улаанбаатар, 2007 он. 110-р тал
27. Л.Чулуунбаатар, *Аман орчуулгад анхаарах зүйл бий*, Орчуулах эрдэм (3), “Орчуулга болон тользүйн асуудалд” Олон улсын хурлын өгүүллийн эмхэтгэл, Улаанбаатар, 2011.05 сар,
28. Дай юань улсын түүх. Бээжин, 1987.
29. *Алтан улсын түүх*, Бээжин, 1988.
30. Жао Хун “*Монгол татарын бүрэн тэмдэглэл*” Хөх хот., 1985

31. Cebel, *Ulus-un nom-un sang-un Azi-yin анги-dur bukui monggol анги-yin bicimel ba darumal nom bicig-ud-un buridkel*, Ulaganbagatur, 1937, (III+161);
32. Jaddungba, *Ulus-un neyitu-yin nom-un sang-un bicimel jokiyal-un nom-un* □*garcig*, Ulaganbagatur, 1960, (III+117).
33. Qaserdeni, Monggol kelen-u *Takimdagu bicig-un uge butuhu yosun*, - Erdem sinjilegen-u sedkul, Kukeqota, 1991, N. 2 (33), .
34. Умар газар одсон хувийн тэмдэглэл, Умрыг төвшитгөсөн тэмдэглэл, Улаанбаатар, Содпресс ХХК, 2016.
35. Ц.Базаррагчаа, “Самуурлаас алан одохуй”, "Монголын Хятад судлал" МУИС, Туршилтын дугаар, Улаанбаатар, 2014, 204-220-р тал

Орос хэлээрх ном товхимол:

1. Б. Ринчэн, *Ойратские переводы с китайского*, - Rocznik Orientalistyczny, Tom. XXX, I, Warszawa, 1966,
2. Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971,
3. Д. Ёндон, *Сказочные сюжеты в памятниках тибетской и монгольской литератур*, Москва, 1989;
4. Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981,
5. В.Я.Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920,
6. В.А.Алексеев, *Китайская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920,

Англи хэлээрх ном товхимол:

1. Boris Riftin, *Mongolian translations of old Chinese novels and stories - A tentative bibliographic survey*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987,
2. Franzoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987,
3. Louis Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, edited by L. Ligeti, Budapest, 1970,

4. L. Ligeti, *A propos de la traduction mongole préclassique de Hiao-king*, - Acta Orientalia Hung., Tom. 38, Budapest, 1984,
5. I. de Rachewiltz, *The Preclassical Mongolian Version of the Hsiao-ching*, - Zentralasiatische Studien, Band 16, Wiesbaden, 1982,
6. I. de Rachewiltz, *More about the preclassical mongolian version of the Hsiao-ching*, - Zentralasiatische Studien, Band 19, Wiesbaden, 1986,
7. F.W.Cleaves, *The First Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - Acta Orientalia Hung., Tom. 36, Budapest, 1982,
8. F.W.Cleaves, *The second Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - Documenta Barbarorum, Festschrift für Walter Heissig zum 70. Geburtstag, Wiesbaden, 1983,
9. B.Csongor, *On the Prehistory of the Shui-Hu-chuan*, - Acta Orientalia Hung., T. XXV, Budapest, 1972,
10. B.Csongor, *On the Popularity of the Shui-Hu-chuan (An Interpretation)*, - Acta Orientalia Hung., T. XXVIII, Budapest, 1974,
11. B.Csongor, *A Comparative Analysis of Shui-Hu-chuan and Hsi-Yu-chi : Rounds of the Classic Chinese Novels*, - Acta Orientalia Hung., T. XXIX, Budapest, 1975,

Хятад хэлээрх ном зохиол:

1. 黑鞑事略（彭大雅撰）（蒙文）
2. 蒙汉合璧四书，蒙藏委员会印，中华民国六十年元月
3. 乌云娜，清代蒙译汉小说版本述略《民族文学研究》2009年3期
4. 唐吉思，论清代汉文作品的蒙译，《民族翻译》，2011年第4期

Герман хэлээрх ном товхимол:

1. E.Haenisch, *Der Chinesische Roman im Mongolischen Schrifttum*, - Ural-Altäische Jahrbucher, Band 30, Wiesbaden, 1958;
2. W. Heissig, *Geschichte der mongolischen Literatur*, Band 1-2, Wiesbaden, 1972.

Веб хуудасны хаяг:

<http://nar-sar.blogspot.com/2009/05/blog-post.html>

<http://ayurzana.mn/>

http://smlc.num.edu.mn/index.php?option=com_content&view=article&id=355

<http://cyrillic.surag.net/?p=303>